СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/168/-НА-СТА-ТШЗ


Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум

2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн:Пийк-Ом Аудит ХХК

Утас: 99862066 Цахим хаяг:peakomaudit@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт…....................................................................3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан ........................................................................5
2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........................................................6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .................................9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....................................................10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ....................................................11
3.Аудитын тайлан ...................................................................................................12
3.1. Ерөнхий зүйл .....................................................................................................12
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ...................................................12
3.4. Материаллаг байдал.............................................................................................13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....................................................................13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ........................................15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.........................................15
3.8 Аудитын гол асуудал..............................................................................................16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ......16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........................................................16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт..........................................................................17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..........................................................17
4.1 Залруулсан алдаа ..................................................................................................18
4.2 Зөвлөмж .................................................................................................................18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.........................................................18

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| НА | Нотлох ажил |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| СЭА | Сэлэнгэ аймаг |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.25 № СЭА-2022/168-НА-СТА-ТШЗ

танай ______________-ны № ______________

СЭЛЭНГЭ АЙМГИЙН САЙХАН СУМЫН
2 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Ц.БЯМБАДОРЖ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сайхан сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.



01802033

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭНХТУЯА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **27,931,412.32** | **36,568,065.50** |
| **33** | **АВЛАГА** | **-** | **392,613.18** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 392,613.18 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **27,931,412.32** | **36,175,452.32** |
| **35400** | **Хангамжийн материал** | **27,931,412.32** | **36,175,452.32** |
| 35410 | Бичиг хэргийн материал | - | 20,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 8,899,478.60 | 8,625,278.60 |
| 35460 | Хүнсний материал | - | 174,240.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 19,031,933.72 | 27,355,933.72 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **410,296,305.39** | **448,891,611.79** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **410,296,305.39** | **448,891,611.79** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **398,782,805.39** | **437,690,611.83** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 391,547,239.00 | 433,447,239.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (24,113,619.00) | (41,957,165.04) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 41,162,105.68 | 34,613,951.68 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (16,516,286.51) | (16,948,683.91) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 12,335,880.00 | 15,138,880.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (8,360,062.78) | (5,018,630.54) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 4,528,701.00 | 21,590,701.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (1,801,152.00) | (3,175,680.36) |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **11,513,500.00** | **11,200,999.96** |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (512,500.00) | (825,000.04) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 10,576,000.00 | 10,576,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **438,227,717.71** | **485,459,677.29** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **29,358,476.00** | **30,530,343.90** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **29,358,476.00** | **30,530,343.90** |
| **41300** | **Өглөг** | **29,358,476.00** | **30,530,343.90** |
| **41360** | **Бусад өглөг** | **29,358,476.00** | **30,530,343.90** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 29,358,476.00 | 30,530,343.90 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **408,869,241.71** | **454,929,333.39** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **408,869,241.71** | **454,929,333.39** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 237,714,148.00 | 237,714,148.00 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **(60,670,881.08)** | **(14,610,789.40)** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (149,570,878.20) | (60,670,881.08) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 88,899,997.12 | 46,060,091.68 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 231,825,974.79 | 231,825,974.79 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **438,227,717.71** | **485,459,677.29** |

## 2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **539,241,939.00** | **505,672,008.68** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **99,419,039.00** | **70,821,408.68** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **99,419,039.00** | **70,821,408.68** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **0** | **4,347,299.00** |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 0 | 4,347,299.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 98,200,099.00 | 63,616,763.68 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 1,218,940.00 | 2,857,346.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **439,822,900.00** | **434,850,600.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **379,429,500.00** | **375,487,500.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 379,429,500.00 | 375,487,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **0** | **276,000.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0 | 276,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **60,393,400.00** | **59,087,100.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 60,393,400.00 | 59,087,100.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **449,123,001.88** | **456,787,171.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **449,123,001.88** | **456,787,171.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **405,178,028.88** | **426,988,251.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **259,288,645.00** | **272,610,430.82** |
| 210101 | Үндсэн цалин | 194,103,001.00 | 218,122,464.82 |
| 210102 | Нэмэгдэл | 44,372,053.00 | 33,700,189.00 |
| 210104 | Урамшуулал | 20,813,591.00 | 20,787,777.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **32,227,789.00** | **34,893,656.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,238,183.00 | 24,458,898.15 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,597,310.00 | 2,647,077.85 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,108,652.00 | 2,229,373.23 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 465,800.00 | 494,848.45 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,817,844.00 | 5,063,458.32 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **54,530,909.00** | **59,739,274.90** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,809,625.00 | 4,588,795.00 |
| 210302 | Түлш, халаалт | 45,897,699.00 | 48,973,044.90 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,823,585.00 | 6,177,435.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **2,084,492.88** | **2,707,873.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 174,800.00 | 405,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 121,000.00 | 48,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 91,530.00 | 431,773.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 19,967.00 | 0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 695,000.00 | 1,240,200.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 326,800.00 | 582,100.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 655,395.88 | 0 |
| **2105** | **Нормативт зардал** | **26,521,000.00** | **21,633,660.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 111,500.00 | 111,400.00 |
| 210502 | Хоол, хүнс | 25,989,500.00 | 20,845,860.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 420,000.00 | 676,400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **3,678,200.00** | **1,872,700.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0 | 500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,678,200.00 | 1,372,700.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **40,000.00** | **178,400.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 40,000.00 | 178,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,019,520.00** | **1,156,600.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 695,520.00 | 665,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | 491,600.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **25,787,473.00** | **32,195,656.28** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 405,000.00 | 0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,048,976.00 | 2,764,900.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 23,333,497.00 | 29,430,756.28 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **43,944,973.00** | **29,798,920.00** |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **43,944,973.00** | **29,798,920.00** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 43,944,973.00 | 29,798,920.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **90,118,937.12** | **48,884,837.68** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **1,218,940.00** | **2,824,746.00** |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 0 | 2,824,746.00 |
| 225011 | Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал | 1,218,940.00 | 0 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **88,899,997.12** | **46,060,091.68** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **439,822,900.00** | **434,850,600.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **439,822,900.00** | **434,850,600.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **379,429,500.00** | **375,487,500.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 379,429,500.00 | 375,487,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **-** | **276,000.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 276,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **60,393,400.00** | **59,087,100.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 60,393,400.00 | 59,087,100.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **429,649,900.00** | **434,788,600.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **429,649,900.00** | **434,788,600.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **385,704,927.00** | **404,989,680.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **259,315,438.00** | **273,006,251.00** |
| 210101 | Үндсэн цалин | 178,264,958.00 | 205,733,045.00 |
| 210102 | Нэмэгдэл | 60,077,043.00 | 46,382,589.00 |
| 210104 | Урамшуулал | 20,973,437.00 | 20,890,617.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **32,197,789.00** | **34,893,656.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,208,180.00 | 24,458,898.15 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,597,310.00 | 2,647,077.85 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,108,652.00 | 2,229,373.23 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 465,800.00 | 494,848.45 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,817,847.00 | 5,063,458.32 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **59,564,200.00** | **58,564,200.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,809,625.00 | 4,588,795.00 |
| 210302 | Түлш, халаалт | 46,598,250.00 | 47,797,970.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8,156,325.00 | 6,177,435.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **1,989,230.00** | **2,417,273.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 174,800.00 | 431,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 121,000.00 | 48,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 91,530.00 | 431,773.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 127,200.00 | 65,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,150,000.00 | 585,200.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 324,700.00 | 856,100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **24,668,750.00** | **30,332,700.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 111,500.00 | 111,400.00 |
| 210502 | Хоол, хүнс | 23,385,250.00 | 21,048,900.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,172,000.00 | 9,172,400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **3,845,200.00** | **1,872,700.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 167,000.00 | 500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,678,200.00 | 1,372,700.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **40,000.00** | **178,400.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 40,000.00 | 178,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,019,520.00** | **1,156,600.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 695,520.00 | 665,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | 491,600.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **3,064,800.00** | **2,567,900.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 495,000.00 | - |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,569,800.00 | 2,567,900.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **43,944,973.00** | **29,798,920.00** |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **43,944,973.00** | **29,798,920.00** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 43,944,973.00 | 29,798,920.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **10,173,000.00** | **62,000.00** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **10,173,000.00** | **62,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **10,173,000.00** | **62,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **10,173,000.00** | **62,000.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 10,173,000.00 | 62,000.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(10,173,000.00)** | **(62,000.00)** |
| **VII** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН** | **-** | **-** |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | **-** | **-** |
| **25** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ** | **-** | **-** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **-** | **-** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **237,714,148.00** | **232,846,849.79** | **(150,591,753.20)** | **319,969,244.59** |
| **2** | **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | **-** | **-** | **1,020,875.00** | **1,020,875.00** |
| **3** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **237,714,148.00** | **232,846,849.79** | **(149,570,878.20)** | **320,990,119.59** |
| **4** | **Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт** | **-** | **(1,020,875.00)** | **-** | **(1,020,875.00)** |
| **5** | **Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт** | **-** | **-** | **-** | **-** |
| **6** | **Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз** | **-** | **-** | **-** | **-** |
| **7** | **Өмчид гарсан өөрчлөлт** | **-** | **-** | **-** | **-** |
| **8** | **Зарласан ногдол ашиг** | **-** | **-** | **-** | **-** |
| **9** | **Тайлант үеийн үр дүн** | **-** | **-** | **88,899,997.12** | **88,899,997.12** |
| **10** | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **237,714,148.00** | **231,825,974.79** | **(60,670,881.08)** | **408,869,241.71** |
| **11** | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **237,714,148.00** | **231,825,974.79** | **(60,670,881.08)** | **408,869,241.71** |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **237,714,148.00** | **231,825,974.79** | **(60,670,881.08)** | **408,869,241.71** |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | - | - | - | - |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | - | - | - | - |
| 16 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| 17 | Өмчид гарсан өөрчлөлт | - | - | - | - |
| 18 | Зарласан ногдол ашиг | - | - | - | - |
| 19 | Тайлант үеийн үр дүн | - | - | 46,060,091.68 | 46,060,091.68 |
| **20** | **2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **237,714,148.00** | **231,825,974.79** | **(14,610,789.40)** | **454,929,333.39** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **434,574,600.00** | **404,775,680.00** | **29,798,920.00** | **93.14** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **434,574,600.00** | **404,775,680.00** | **29,798,920.00** | **93.14** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **434,574,600.00** | **404,775,680.00** | **29,798,920.00** | **93.14** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **287,642,600.00** | **273,006,251.00** | **14,636,349.00** | **94.91** |
| 210101 | Үндсэн цалин | 214,784,400.00 | 205,733,045.00 | **9,051,355.00** | **95.79** |
| 210102 | Нэмэгдэл | 51,848,600.00 | 46,382,589.00 | **5,466,011.00** | **89.46** |
| 210104 | Урамшуулал | 21,009,600.00 | 20,890,617.00 | **118,983.00** | **99.43** |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **37,544,800.00** | **34,893,656.00** | **2,651,144.00** | **92.94** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 26,039,100.00 | 24,458,898.15 | **1,580,201.85** | **93.93** |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,876,400.00 | 2,647,077.85 | **229,322.15** | **92.03** |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,301,100.00 | 2,229,373.23 | **71,726.77** | **96.88** |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 575,300.00 | 494,848.45 | **80,451.55** | **86.02** |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,752,900.00 | 5,063,458.32 | **689,441.68** | **88.02** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **58,564,200.00** | **58,564,200.00** | **-** | **100.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,526,800.00 | 4,588,795.00 | **4,938,005.00** | **48.17** |
| 210302 | Түлш, халаалт | 40,451,900.00 | 47,797,970.00 | **(7,346,070.00)** | **118.16** |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8,585,500.00 | 6,177,435.00 | **2,408,065.00** | **71.95** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **2,203,300.00** | **2,203,273.00** | **27.00** | **100.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 174,700.00 | 431,000.00 | **(256,300.00)** | **246.71** |
| 210402 | Тээвэр, шатахуун | 220,500.00 | 48,200.00 | **172,300.00** | **21.86** |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 591,500.00 | 431,773.00 | **159,727.00** | **73.00** |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 775,100.00 | 309,200.00 | 465,900.00 | **39.89** |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 314,500.00 | 856,100.00 | (541,600.00) | **272.21** |
| **2105** | **Нормативт зардал** | **42,356,700.00** | **30,332,700.00** | **12,024,000.00** | **71.61** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 111,400.00 | 111,400.00 | 1.00 | **100.00** |
| 210502 | Хоол, хүнс | 33,072,900.00 | 21,048,900.00 | 12,024,000.00 | **63.64** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 9,172,400.00 | 9,172,400.00 | - | **100.00** |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,872,700.00** | **1,872,700.00** | - | **100.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 500,000.00 | 500,000.00 | - | **100.00** |
| 210604 | Урсгал засвар | 1,372,700.00 | 1,372,700.00 | **-** | **100.00** |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **178,600.00** | **178,400.00** | **200.00** | **99.89** |
| 210702 | Дотоод албан томилолт | 178,600.00 | 178,400.00 | **200.00** | **99.89** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний** | **1,643,800.00** | **1,156,600.00** | **487,200.00** | **70.36** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил | 671,800.00 | 665,000.00 | **6,800.00** | **98.99** |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 972,000.00 | 491,600.00 | **480,400.00** | **50.58** |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **2,567,900.00** | **2,567,900.00** | **-** | **100.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,567,900.00 | 2,567,900.00 | **-** | **100.00** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **434,574,600.00** | **434,574,600.00** | **-** | **100.00** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **375,487,500.00** | **375,487,500.00** | **-** | **100.00** |
| 310003 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 375,487,500.00 | 375,487,500.00 | **-** | **100.00** |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **59,087,100.00** | **59,087,100.00** | **-** | **100.00** |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 59,087,100.00 | 59,087,100.00 | **-** | **100.00** |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **268.00** | **268.00** | **-** | **100.00** |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1.00** | **1.00** | **-** | **100.00** |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **26.00** | **26.00** | **-** | **100.00** |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | **215.00** | **215.00** | **-** | **100.00** |
| **631** | **СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА** | **215.00** | **215.00** | **-** | **100.00** |
| 631001 | Төрийн өмчит СӨБ байгууллага | 215.00 | 215.00 | **-** | **100.00** |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **26.00** | **26.00** | **-** | **100.00** |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 26.00 | 26.00 | **-** | **100.00** |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **276,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **276,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | **276,000.00** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | **276,000.00** |
| 210401 | Бичиг хэрэг | | |
| 210402 | Тээвэр, шатахуун | | |
| 210406 | Хог хаягдал, хортон шавьж | | 276,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | | **0** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | 0 |
| 210502 | Хоол, хүнс | | 0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | 0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 0 |
| 210602 | Тавилга | | 0 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | 0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | |
| **210901** | Бараа үйлчилгээний бусад зардал | | |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | **0** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 0 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | | **0** |
| **213303** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг** | | 0 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | **276,000.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | **276,000.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | **276,000.00** |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | **0** |
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **0** |
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **0** |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сайхан сумын 2 дугаар цэцэрлэгийн */цаашид Сайхан сумын 2 дугаар цэцэрлэг/* 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн төлбөрийн цахим баримттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу Пийк-Ом Аудит ХХК-ийн аудитор А.Батболд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сайхан сумын 2 дугаар цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Пийк-Ом Аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сайхан сумын 2 дугаар цэцэрлэг нь тайлант онд “*Хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад бүх талуудтай хамтран ажиллая*” гэсэн зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Сайхан сумын 2 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Сургуулийн өмнөх насны  боловсрол олгох

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр  тогтоол “Босго  үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар шинэчлэгдсэн,

- Боловсролын тухай хуулийн 40 дүгээр зүйл.Төрийн өмчийн боловсролын сургалтын байгууллагын санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн .

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэж байна.

Тус цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна.

### 3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сайхан сумын 2 дугаар цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 456,787,1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 4,567,8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 буюу 3,197,5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сайхан сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 47,232.00 мянган төгрөгөөр буюу 10.7 хувиар нэмэгдсэн байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгө,засгийн газрын оролцоо дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна.

*Хүснэгт 1:* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | | - |
| Авлага | - | **392.60** | 392.60 |
| Бараа материал | **27,931.30** | **36,175.40** | 8,244.10 |
| Үндсэн хөрөнгө | **410,296.30** | **448,891.60** | 38,595.30 |
| Нийт хөрөнгө | 438,227.60 | 485,459.60 | 47,232.00 |
| Өр төлбөр | **29,358.40** | **30,530.30** | 1,171.90 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | **408,869.20** | **454,929.30** | 46,060.10 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 438,227.60 | 485,459.60 | 47,232.00 |

Тайлант онд авлага данс 392.6 мянган төгрөгөөр өссөн нь ХХОАТ-ын хөнгөлөлтийн тооцооны зөрүүгээс үүссэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 36,175.4 мянган төгрөг болж 8,244.1 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 35,425.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, хандиваар БСГ-аас 134.0 мянган төгрөгийн гар ариутгагч, маск, бээлий, нөмрөг, Дэлхийн зөн олон улсын байгууллагаас 238,1 мянган төгрөгийн санитоль, халуун хэмжигч нийт 372.1 мянган төгрөгийн бараа материалыг тус тус үнэ төлбөргүй орлогоор бүртгэж, 27,155.2 мянган төгрөгийн материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл */анхны өртгөөр/* 516,816.8 мянган төгрөг болж өмнөх оноос 38,594.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 62.0 мянган төгрөгийн ном төсвийн хөрөнгөөр худалдан авч, 41,900.0 мянган төгрөгийн урсгал засвар хандиваар хийгдсэнийг капиталжуулж, 3,400.0 мянган төгрөгийн тоглоом, 17,000.0 мянган төгрөгийн цэцэрлэгийн хашааг тус тус үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэнтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 30,530.3 мянган төгрөг болж өмнөх оноос 1,171.9 мянган төгрөгөөр өссөн байна. Энэхүү өр нь 2018 оноос хуримтлагдсан м3 талбайн жишиг үнийг төсөвт дутуу тусгаж, батлуулснаас үүссэн дулааны өр төлбөртэй холбоотой байна

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 454,929.3 мянган төгрөг болж 46,060.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 505,672.0 мянган төгрөг болж өмнөх оноос 33,570.0 мянган төгрөгөөр буюу 6.2 хувиар буурсан байна. Энэ нь 34,583.3 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлого буурсантай холбоотой байна.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 456,787.1 мянган төгрөг болж өмнөх оноос 7,664.2 мянган төгрөгөөр буюу 1.7 хувиар өссөн нь Ковид-19 цар тахлын улмаас цалингийн зардал 13,321.8 мянга, тогтмол зардал 5,207.4

мянга, бараа үйлчилгээний бусад зардал 6,408.2 мянган төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Сайхан сумын 2 дугаар цэцэрлэг нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг тус бүр 457,304.3 мянган төгрөгөөр тооцон төсөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 22,729.7 мянган төгрөгөөр бууруулан, **434,574.6** мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 434,574.6 мянган төгрөгийн төсөв батлснаас 375,487.5 мянган төгрөгийг улсын төсвөөс */тусгай зориулалтын шилжүүлгээр/*, 59,087.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 375,487.5 мянган төгрөгийн орон нутгийн төсвөөс 59,087.1 мянган төгрөг, нийт 434,574.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 404,775.6 мянган төгрөгийг зарцуулж, төсвийн зарлагын хэмнэлтийн 29,799.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **404,775.6** мянган төгрөг буюу 93.1 хувьтай тайлагнагдсан нь цалин ба нэмэгдэл хөлс 14,636.3 мянга, норматив зардал 12,014.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд БСГ-аас цэцэрлэгийн ариутгалын санхүүжилтэд 276.0 мянган төгрөгийн олгосныг Мөнх Ариун Сэлэнгэ ХХК-аар ариутгал хийлгэж зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

**3.7.1** Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журмын 3

дахь “Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно.” гэсэн заалт болон Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35,А/10/9 тушаалын 10 дахь “*цэцэрлэг, сургуулийн түвшинд амжилт гаргасан 10 хувь, сум, дүүргийн түвшинд амжилт гаргасан 15 хувь, аймаг, нийслэлийн түвшинд амжилт гаргасан 20 хувь, улс, бүс, олон улсын түвшинд амжилт гаргасан 25 хувь”* гэж заасан боловч цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, багш, туслах багшийн ажлын үр дүнг нь шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнэлгүйгээр ур чадварын нэмэгдлийг сард 10-25 хувиар тооцож олгож байна. Цаашид ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж дүгнэн олгож байх нь зүйтэй юм.

**3.7.2** БШУ-ны сайд болон Эрүүл мэндийн сайдын 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/292, А/525 дугаар хамтарсан “Түр журам журам батлах тухай” тушаалын нэгдүгээр хавсралт “Короновируст халдварын үед цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх түр журам”-ын дагуу сургалтын үйл ажиллагааг танхим болон танхимын бус сургалтад шилжүүлсэн байна..

### 3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс 131 мэдээллийг хугацаанд нь оруулж, 17 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Сайхан сумын 2 дугаар цэцэрлэгт 435,574.6 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 404,775.6 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 7.1 хувиар хэмнэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: *“.....батлагдсан төсөвт зардлын дунд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”* гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3,358.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 төлбөрийн акт, зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулж гүйцэтгэлийг бодитой тайлагнаагүй алдаа зөрчилд 1 албан шаардлага, шилэн дансны мэдээлэлтэй холбоотой 1 зөвлөмж өгснөөс төлбөрийн актыг барагдуулж, албан шаардлагыг хэрэгжүүлсэн боловч зөвлөмж хэрэгжээгүй байна

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | |
| Төлбөрийн акт | 3 | 758.6 | 3 | 758.6 | 100 |
| Зөвлөмж | 1 | | | | |
| **Нийт дүн** | **4** | **758.6** | **3** | **758.6** | **75** |

Өмнөх аудитаар өгсөн холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх ”Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: *“Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол”* гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

3.11.1 Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 189,074.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 105,545.0 мянган төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж, 392.6 мянган төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлж, 83,136.4 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өглөө.

### 4.1 Залруулсан алдаа

- Барилгын урсгал засварын 41,600.0 мянган төгрөгийг капиталжуулж, бүртгээгүй,
- Өмнөх оны үр дүнгийн тайланд 63,945.0 мянган төгрөгийн зардал дутуу илэрхийлсэн байсныг тус тус залруулав.

### 4.2 Албан шаардлага

*1.1 Илрүүлэлт:* Төсвийг зохистой удирдаагүй, авлага, өр төлбөрийн тооцоог хянан баталгаажуулаагүйгээс ХХОАТ-ын 392.6 мянган төгрөгийн авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*1.2 Шийдвэрлэсэн нь:* Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэх

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав.

***1. Анхан шатны баримт хөтлөлт, бүрдүүлэлттэй холбоотой асуудал***

***1.1 Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд***

*1.1.1 Илрүүлэлт:* Тайлант онд 83,136.4 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

*1.1.2 Өгсөн зөвлөмж:* Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “*Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”* гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “*Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ”* гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Сэлэнгэ аймгийн Сайхан сумын 2 дугаар цэцэрлэг | 4 | 189,074.0 | 2 | 105,545.0 | | | 1 | 392.6 | 1 | 83,136.4 |